



EGMO 2018  
Florence | April 9<sup>th</sup>-15<sup>th</sup>

Language: Mongolian

Day: 1

Лхагва, 4 сарын 11, 2018

**Бодлого 1.**  $CA = CB$  ба  $\angle ACB = 120^\circ$  байх  $ABC$  гурвалжны  $AB$  талын дундаж цэгийг  $M$  гэе.  $P$  нь  $ABC$  гурвалжныг багтаасан тойрог дээр гүйх цэг,  $Q$  нь  $QP = 2QC$  байх  $CP$  хэрчмийн цэг болог.  $P$  цэгийг дайрсан  $AB$ -д перпендикуляр шулуун  $MQ$  шулууныг цор ганц  $N$  цэгт огтолно.

$P$  цэгийн бүх боломжит байрлалд харгалзах  $N$  нэг тойрог дээр оршино гэж батал.

**Бодлого 2.** Дараах олонлогийн авч үзье:

$$A = \left\{ 1 + \frac{1}{k} : k = 1, 2, 3, \dots \right\}.$$

(a) Бүхэл тоо  $x \geq 2$  бүрийг  $A$  олонлогийн нэг эсвэл хэдэн элементүүдийн (ялгаатай байх албагүй) үржвэр хэлбэрт бичиж болохыг батал.

(b) Бүхэл тоо  $x \geq 2$  бүрийн хувьд  $x$ -г  $A$  олонлогийн  $f(x)$  ширхэг элементийн (ялгаатай байх албагүй) үржвэр хэлбэрт бичиж болдог байх хамгийн бага тоог  $f(x)$  гэж тэмдэглэе.

$x \geq 2, y \geq 2$  ба  $f(xy) < f(x) + f(y)$  байх төгсгөлгүй олон бүхэл тоон  $(x, y)$  хос олдохыг батал.

(Хэрэв  $x_1 \neq x_2$  эсвэл  $y_1 \neq y_2$  бол  $(x_1, y_1)$  ба  $(x_2, y_2)$  хосууд ялгаатай).

**Бодлого 3.** EGMO-ийн  $n$  оролцогчийг  $C_1, \dots, C_n$  гэе. Бодолтын дараа дараах дүрмийн дагуу тэд ресторанд орохоор нэг эгнээнд дараалан зогсов.

- Оролцогчдыг нэг эгнээнд зогсоох эхний дарааллыг Жюри сонгоно.
- Минут тугамд  $1 \leq i \leq n$  байх  $i$  дугаарыг Жюри сонгоно.
  - Хэрэв  $C_i$  оролцогчийн урд дор хаяад  $i$  оролцогч байвал тэр 1 евро Жюрид төлж яг  $i$  байраар урагшилдаг.
  - Хэрэв  $C_i$  оролцогчийн урд  $i$ -с цөөн оролцогч байвал ресторан нээгдэж үйлдэл зогсдог.

(a) Жюригийн сонголтуудаас үл хамааран үйлдэл төгсгөлгүй үргэлжлэх боломжгүй гэдгийг үзүүл.

(b)  $n$  бүрийн хувьд эхний байрлал болон үйлдлийг ухаалгаар сонгосноор Жюри хамгийн ихдээ хэдэн евро цуглуулж чадахыг тодорхойл.